



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ



ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
СҮРГАЛТ, ҮНЭЛГЭЭ, СУДАЛГААНЫ
ИНСТИТУТ

МАЛЧДЫН ОРЛОГО, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА



2023 он



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

**ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**



ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
СУРГАЛТ, ҮНЭЛГЭЭ, СУДАЛГААНЫ
ИНСТИТУТ

Малчдын орлого, хөдөлмөр эрхлэлтийн судалгаа

Захиалагч : Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын бодлого
хэрэгжилтийн газар

2023 он



Судалгааг гүйцэтгэсэн:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт,
үнэлгээ, судалгааны институт,

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын
бодлогын судалгааны сектор

Судалгааг гүйцэтгэсэн багийн гишүүд:

Б.Батбаатар	ХНХСҮСИ-ийн захирал
М.Доржпагам	Судалгааны газрын дарга
Б.Эрдэнэтуяа	ХАХНХБСС-ын эрхлэгч
Э.Туяацэцэг	ХАХНХБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
М.Энхзориг	ХАХНХБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
Т.Мөнхбат	ХАХНХБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
А.Алтанхуяг	ХАХНХБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
Б.Хос-Эрдэнэ	Дотоод сүлжээ, техник хангамж хариуцсан мэргэжилтэн
Б.Халиунаа	МТА-ны эрдэм шинжилгээний ажилтан

Утас: 77121286

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо
Чингисийн өргөн чөлөө, Хөдөлмөрийн ордон, 5 дугаар давхар

Вэб хуудас: www.institute.gov.mn



АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	ii
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	iii
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	iv
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	1
Үндэслэл.....	2
Судалгааны зорилго, зорилтууд.....	2
Судалгааны арга зүй.....	3
Судалгааны төлөвлөлт, зохион байгуулалт.....	4
МАЛЧИД, МАЛЧИН ӨРХИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	7
СУДАЛГААНЫ ҮР ДҮН	15
Хүн ам зүйн шинж байдал.....	16
Өрхийн амьжиргаа, хэрэглээ.....	20
Малчин өрхийн сарын дундаж орлого.....	20
Малчин өрхийн сарын дундаж зарлага.....	23
Урамшуулалд хамрагдсан байдал.....	30
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын хамрагдалт.....	31
ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ	35



ӨМНӨХ ҮГ

Манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр суурь эзэлдэг салбарын нэг юм. Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь хүмүүсийн хоол хүнс, өмсөж зүүх, хувцас хунар зэрэг амьжиргааны бүхий л хэрэгцээг хангадаг эдийн засгийн гол салбар хэвээрээ байна.

2022 оны эцсийн байдлаар 248.2 мянган малтай өрх байгаагийн 76.8% нь буюу 190.7 мянган малчин өрх (305.0 мянган малчин) байгаа бөгөөд Монгол улсын нийт хөдөлмөр эрхэлж буй иргэдийн 24.1 орчим хувийг малчид эзэлж байна. Мал аж ахуйн салбар нь хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний шингээлт өндөртэй голлох салбар боловч 300 мянга гаруй малчдын дөнгөж 12.4% нь нийгмийн даатгалд хамрагдсан байгаа юм. Энэ нь малчдын нийгмийн баталгаа алдагдах эрсдэлд байгааг илтгэх бөгөөд зайлшгүй анхаарах шаардлагатай асуудал юм.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт (хуучин нэрээр) нь 2018 онд “Малчдын аж байдал судалгаа”-г үндэсний хэмжээнд малчдын хувьсан өөрчлөгдөж буй нийгмийн хөгжилд дасан зохицох, тэдний гэр бүлийн байдал, нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах нөхцөл, боломж зэрэг аж төрөх ёсны ерөнхий үзүүлэлтүүдийг нарийвчлан судалж байсан.

Нийгмийн даатгалын багц хууль гарсантай холбогдуулан Салбарын яамны захиалгаар малчдын орлого, хөдөлмөр эрхлэлтийн байдлыг судалж, малчдын нийгмийн даатгалын шимтгэлийн зохистой хэмжээг тодорхойлохоор “Малчдын орлого, хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-г хийж, гүйцэтгэлээ. Та бүхэн судалгааны үр дүнтэй танилцан, өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглахын зэрэгцээ судалгааны арга, аргачлалтай холбоотой санал хүсэлтээ бидэнд илгээж, хамтран ажиллахыг хүсье.

Хүндэтгэсэн,

Захирал

Б.Батбаатар



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Нийгмийн даатгалд сайн дураар хамрагдсан малчдын тоо, тухайн насны малчдад эзлэх хувь, хүйсээр, 2022 он.....	11
Хүснэгт 2. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан малчдын тоо, тухайн насны малчдад эзлэх хувь, хүйсээр, 2022 он.....	13
Хүснэгт 3. Малчин өрхийн сарын дундаж орлого, хонин толгойд шилжүүлсэн малын тооны бүлэг, бүтэц, хувиар.....	21
Хүснэгт 4. Малчин өрхийн сарын дундаж орлого, хонин толгойд шилжүүлсэн малын тооны бүлэг, орлогын эх үүсвэрээр, мянган төгрөг.....	23
Хүснэгт 5. Малчин өрхийн сарын дундаж зардал, хонин толгойд шилжүүлсэн малын тооны бүлэг, бүтцээр, хувиар.....	25
Хүснэгт 6. Малчин өрхийн сарын дундаж зарлага, хонин толгойд шилжүүлсэн малын тооны бүлэг, орлогын эх үүсвэрээр, мянган төгрөг.....	27
Хүснэгт 7. Нийгмийн даатгалд хамрагдаагүй шалтгаан насны бүлгээр.....	32

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Мэдээлэл цуглуулах үйл явцын зураглал.....	3
Зураг 2. Судалгаанд хамрагдсан баг, хороо.....	5
Зураг 3. Мэдээллийн хяналт.....	6
Зураг 4. Малчид, малчин өрхийн тоо, мянган хүн, 2015-2022 он.....	8
Зураг 5. Малчдын тоо, хүйс, насны бүлгээр, мянган хүн, 2022 он.....	8
Зураг 6. Малчдын тоо, аймгаар, мянган хүн, 2022 он.....	9
Зураг 7. Малтай өрхийн тоо, мянган хүнээр, малын тооны бүлгээр, 2022 он.....	9
Зураг 8. Нийгмийн даатгалд сайн дураар хамрагдсан малчдын тоо, хүйсээр, мянган хүн, 2022 он.....	10
Зураг 9. Нийгмийн даатгалд сайн дураар хамрагдсан малчдын тоо, хүйс, насны бүлэг, хувиар, 2022 он.....	10
Зураг 10. Нийгмийн даатгалд сайн дураар хамрагдсан малчдын тоо, нийт малчдад эзлэх хувь, аймгаар, мянган хүн, 2022 он.....	12
Зураг 11. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан малчдын тоо, хүйсээр, мянган хүн, 2022 он.....	12
Зураг 12. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан малчдын тоо, нийт малчдад эзлэх хувь, аймгаар, мянган хүн, 2022 он.....	14



Зураг 13. Судалгаанд хамрагдсан малчид, өрхийн хамаарлаар.....	16
Зураг 14. Судалгаанд хамрагдсан малчид, насны бүлэг, хүйсээр.....	16
Зураг 15. Судалгаанд хамрагдсан, боловсролын түвшнээр.....	17
Зураг 16. Судалгаанд хамрагдсан малчид, гэрлэлтийн байдлаар.....	17
Зураг 17. Судалгаанд хамрагдсан малчид, ам бүлийн тоогоор.....	17
Зураг 18. Мал аж ахуйгаас бусад хөдөлмөр эрхлэгч зөвхөн мал аж ахуйгаас бусад хөдөлмөр эрхлэгчдээс дүнд эзлэх хувиар.....	18
Зураг 19. Мал малласан жил, хүйсээр, насны бүлгээр.....	18
Зураг 20. Малчдын ахуйн хүрээн дэх хөдөлмөр эрхлэлт.....	19
Зураг 21. Малчин өрхийн сарын дундаж орлого, эх үүсвэр, хувиар.....	20
Зураг 22. Малчин өрхийн сарын дундаж орлого, эх үүсвэр, мянган төгрөг.....	20
Зураг 23. Малчин өрхийн сарын дундаж орлого, бүтцээр, хувиар.....	21
Зураг 24. Малчин өрхийн сарын дундаж орлого, хот, хөдөөгөөр, мянган төгрөг....	22
Зураг 25. Малчин өрхийн сарын дундаж орлого, хонин толгойд шилжүүлсэн малын тооны бүлгээр, мянган төгрөг.....	22
Зураг 26. Малчин өрхийн сарын дундаж зардал, төрөл, хувиар.....	24
Зураг 27. Малчин өрхийн сарын дундаж зардал, төрөл, мянган төгрөг.....	24
Зураг 28. Малчдын сарын дундаж зардал, бүтэц, хувиар.....	25
Зураг 29. Малчин өрхийн сарын дундаж зардал, хот, хөдөөгөөр, мянган төгрөг...26	
Зураг 30. Малчин өрхийн сарын дундаж орлого, хонин толгойд шилжүүлсэн малын тооны бүлгээр, мянган төгрөг.....	27
Зураг 31. Малчин өрхийн зээл, зээлийн зориулалт, хувиар.....	28
Зураг 32. Зээлтэй малчдын эзлэх хувь, хонин толгойд шилжүүлсэн малын тоогоор.28	
Зураг 33. Малчин өрхийн сарын дундаж орлого, зарлагын зөрүү, мянган төгрөг....29	
Зураг 34. Малчин өрхийн сарын дундаж орлого, зарлагын зөрүү, хот, хөдөөгөөр, мянган төгрөг.....	29
Зураг 35. Малчин өрхийн сарын дундаж орлого, зарлагын зөрүү, хонин толгойд шилжүүлсэн малын тоогоор, мянган төгрөг.....	29
Зураг 36. Мөнгөн урамшуулал авсан малчид, урамшууллын төрөл, хувиар.....	30
Зураг 37. Мөнгөн урамшууллаар НДШ, ЭМД-ыг төлөхийг зөвшөөрсөн малчдын хувь, хонин толгойд шилжүүлсэн малын тооны бүлгээр.....	30
Зураг 38. Судалгаанд хамрагдсан малчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг.....	31



Зураг 39. Хөдөлмөрийн насны гишүүдийн нийгмийн даатгалын хамрагдалт.....	31
Зураг 40. Малчин өрхийн гишүүд сайн дурын даатгалд хамрагдахгүй байгаа шалтгаан.....	32
Зураг 41. Малчид нийгмийн даатгал төлснөөр нийгмийн баталгаа хангагдана гэж бодож буй эсэх.....	33
Зураг 42. Нийгмийн даатгалын шимтгэл хэдэн төгрөг байвал даатгуулах боломжтой болохталаар хариулсан байдал.....	33
Зураг 43. Нийгмийн даатгалын шимтгэлийг хэдийд төлөх боломжтой эсэх.....	34



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ





Үндэслэл

Монгол улсад 2022 оны эцсийн байдлаар 248.2 мянган малтай өрх байгаагийн 76.8% нь буюу 190.7 мянган малчин өрх (305.0 мянган малчин¹) байна. Мал тооллогын 2022 оны дүнгээр малын тоо толгой 71.1 сая болсон байна. Сүүлийн 18 жилд буюу 2003-2021 онд хадлан, бэлчээрийн талбай 113.1-111.3 сая га болж 1.8 сая га-гаар багасаж, хонин толгойд шилжүүлсэн нийт малын тоо 46.2-117.6 сая толгой болж 71.4 саяар буюу 1.5 дахин өсжээ².

Монголчууд олон зууны турш нүүдлийн мал аж ахуй эрхэлж, газарзүйн байршил, цаг уурын онцлогтоо дасан зохицож, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг амьжиргааны гол эх үүсвэрээ болгож ирсэн уламжлалт хэлбэрийг тогтвортой хадгалж, малын ашиг шимийг нэмэгдүүлэхэд Монгол Улсын төр, засгаас анхаарч ирсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас мал аж ахуйн салбарын харилцааг зохицуулж буй 5 хууль, 7 бодлогын баримт бичиг, мөн тус салбарын дэмжлэг, урамшуулал болох “Ноосны урамшуулал”, “Арьс ширний урамшуулал”, “Сүүний урамшуулал”, “Нөөцийн мах бэлтгэлийн урамшуулал” зэрэг мөнгөн дэмжлэгийг өгч байна.³ Гэвч Мал аж ахуйн салбар нь хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний шингээлт өндөртэй голлох салбар (хөдөлмөр эрхэлж буй нийт иргэдийн 30.0) хэдий ч нийт малчдын дөнгөж 12.4 хувь нь⁴ нийгмийн даатгалд хамрагдсан байна. Энэ нь малчдын нийгмийн баталгаа алдагдах эрсдэлд байгааг зайлшгүй анхаарах шаардлагатайг илэрхийлж байна. Малчдыг нийгмийн даатгалд хамруулах талаар бодлого хөтөлбөр, мэдээлэл сурталчилгаа хийж байгаа ч хамрагдалт нь бага байсаар байна.

Иймээс малчдын орлогыг судалж, нийгмийн баталгааг сайжруулахад нийгмийн даатгалын багц хууль, нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх боломжийг судалж, улмаар малчдад тохирох нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээг тодруулах бодит хэрэгцээ нь судалгаа хийх үндэслэл болсон.

Судалгааны зорилго, зорилтууд

Судалгааны зорилго нь малчдын орлого болон хөдөлмөр эрхлэлтийн байдлыг судалж, улмаар малчдын нийгмийн даатгалын шимтгэлийн зохистой хэмжээг тодорхойлж, судалгааны үр дүнд үндэслэн санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна.

- Малчдын хөдөлмөр хуваарилалт;
- Малчин өрхийн орлого тодорхойлох;
- Нийгмийн даатгалын хамрагдалт, сонирхол;
- Зохистой шимтгэлийн хувь хэмжээг тодорхойлох.

¹ҮСХ, www.1212.mn

²ХАА-н 2022 оны Тооллогын нэгдсэн дүн, ҮСХ

³ХАА-н дэмжлэг, урамшууллын судалгааны тайлан, 2023 он

⁴Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээ 2022 он




Судалгааны арга зүй

Судалгааны онцлог хүртээмжийг бодолцон тоон судалгааны аргаар авсан бөгөөд мэдээлэл цуглуулалтыг урьдчилан бэлтгэсэн CSPro талбар бүхий таблет ашиглаж судалгаанд оролцогчтой ярилцах байдлаар мэдээлэл цуглууллаа.

Мэдээлэл цуглуулах үйл явц нэгдүгээрт: CSPro 7.1 программд таблетад суурилуулах асуултын эхний загварыг бэлтгэж, бүх таблетад нэгэн зэрэг байршуулах, хоёрдугаарт: судлаач өгөгдсөн асуулгын дагуу хариулагчаас асуулгын аргаар мэдээлэл цуглуулах, гуравдугаарт: цуглуулсан мэдээллийг утасгүй интернэтийн сүлжээгээр дамжуулан төв систем рүү илгээх, дөрөвдүгээрт: цуглуулсан мэдээлэл автоматаар нэгтгэгдэх, тавдугаарт: талбарын судлаачдын явуулсан мэдээллийг дор бүр нь шалгаж мэдээллийн чанарыг дээшлүүлэх, зургаадугаарт: цуглуулсан нийт мэдээлэлд анхдагч болон хоёрдогч боловсруулалт хийж судалгааны үр дүнг гаргалаа.

Зураг 1. Мэдээлэл цуглуулах үйл явцын зураглал



Асуулгын бүтэц

Судалгааны асуулга, үзүүлэлтийг тодорхойлохдоо судалгааны зорилго, хамрах хүрээнд үндэслэн дараах агуулгын хүрээнд асуулгыг боловсруулсан.

- Хөдөлмөр эрхлэлт;
- Өрхийн орлого;
- Нийгмийн даатгалд хамрагдалт, сонирхол, НД-ын шимтгэлийн зохистой хувь хэмжээ.

Түүвэрлэлт

Түүврийн хэмжээг тооцохдоо 95.0 хувийн итгэх магадлалтай хамгийн ихдээ 5 хувийн алдааны хязгаартай байхаар тооцсон. Нийт түүврийн хэмжээ 880 өрх бөгөөд олон шатлалт түүврийн арга ашигласан.



Түүврийн хэмжээ тооцсон томъёо:

$$n_i = \frac{N_i * X}{X + N_i - 1}$$

Эхний шатанд ҮСХ-ны Мал тооллын 2022 оны албан ёсны статистикийн мэдээг түүврийн хүрээ болгон ашиглав.

Нэгдүгээр шатанд аймаг сонгохдоо:

- *Малчин өрхийн тоо;*
- *Малын тоо;*
- *Малчдын тоо;*
- *Нийгмийн даатгалд сайн дураар хамрагдаж байгаа хувь гэсэн 4 шалгуураар нийт 8 аймаг, Улаанбаатар хотын нэг дүүргийг хамруулахаар тооцсон.*

Хоёрдугаар шатанд сум сонгохдоо:

- *Алслагдсан байдал (хамгийн ойр болон хамгийн хол сум);*
- *Малын тоо;*
- *Малчдын тоог харгалзан 3 сум сонгосон.*

Гуравдугаар шатанд өрхөө сонгохдоо:

- *Малчин өрхийн малын тоо толгой, насны бүлгээс хамаарч пропорционалиар санамсаргүйгээр авсан.*

Судалгааны төлөвлөлт, зохион байгуулалт

“Малчдын орлого, хөдөлмөр эрхлэлт судалгаа”-ны ерөнхий зохион байгуулалт, бэлтгэл ажил 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс эхэлсэн. Судалгааг зохион байгуулахад дараах үндсэн ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Бэлтгэл ажлын хүрээнд:

- *Судалгааны арга зүй, аргачлал боловсруулах;*
- *Судалгааны асуулга, нөхөх зааврыг боловсруулах;*
- *Түүврийн зохиомж боловсруулж, түүвэрлэлт хийх;*
- *Судалгааны мэдээллийг оруулах, шалгах, засварлах, үр дүнгийн хүснэгт гаргах;*
- *Туршилтын судалгаа явуулах;*
- *Туршилтын судалгааны үр дүнд суурилан судалгааны асуулга, нөхөх заавар, оролтын программыг эцэслэн боловсруулах;*
- *Судалгааны мэдээлэл цуглуулагч нарт зориулсан сургалт зохион байгуулах.*

2. Мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд:

- *Мэдээлэл цуглуулах явцад хяналт хийх, зөвлөх.*



3. Боловсруулалт, тайлан бичих ажлын хүрээнд:
 - *Судалгааны мэдээллийг шалгаж, засварлах, кодлох;*
 - *Үр дүнгийн хүснэгтүүдийг боловсруулах.*
4. Үр дүнг хэвлэн нийтлэх ажлын хүрээнд:
 - *Нэгдсэн тайлан боловсруулах.*
5. Судалгааны архив үүсгэх:
 - *Судалгааны бүхий л үе шатны ажилбарыг архивлах.*


Судалгааны мэдээлэл цуглуулалт

Судалгааны мэдээлэл цуглуулах үйл явцыг хоёр үе шаттайгаар зохион байгууллаа. Эхний удаад судалгааны асуулгын агуулга, үзүүлэлтийн уялдаа холбоо, хариулагчид ойлгомжтой байдлыг тодорхойлох, мэдээлэл цуглуулалтын зохион байгуулалт, асуулгад зарцуулж буй хугацаа зэргийг нягталж эцэслэх зорилгоор туршилтын судалгааг 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр Төв аймгийн Эрдэнэ суманд зохион байгуулав. Тус туршилтаар нийт 20 малчин өрхөөс судалгаа авч туршилтын судалгааны үр дүнд асуулгыг эцэслэн засварлаж, баталсан. Батлагдсан удирдамжийн дагуу судалгааны багийн ахлагч, мэдээлэл цуглуулагч нарт судалгааг хэрхэн зохион байгуулах талаар заавар, зөвлөгөө өгч, гарын авлагаар ханган сургалтыг зохион байгууллаа.

Сургалтын дараа Төв аймгийн Эрдэнэ сумын 5, 6 дугаар баг дээр туршилтаар ажиллуулсан бөгөөд гарч буй алдаа, тодорхой бус асуудал газар дээр нь зөвлөгөө өгч дадлагажуулж үндсэн судалгааны мэдээлэл цуглуулалтад хуваарилан ажиллуулсан.

Судалгаанд 8 аймаг, Улаанбаатар хотын 24 сум, нэг дүүрэг, 45 баг, хорооны малчид хамрагдсан.

Зураг 2. Судалгаанд хамрагдсан аймаг






Судалгааны мэдээлэл цуглуулах багийг ахлагч, мэдээлэл цуглуулагч, жолооч гэсэн бүрэлдэхүүнтэй зохион байгуулсан. Мэдээлэл цуглуулах ажлыг 2023 оны 6 дугаар сарын 16-аас хөдөө орон нутагт эхэлж, 2023 оны 7 дугаар сарын 10-ны өдөр дууссан.

Судалгааны мэдээллийн санг дараах схемийн дагуу хяналт хийж, баталгаажууллаа.

Зураг 3. Мэдээллийн хяналт



Мэдээлэл боловсруулалт

Судалгааны мэдээлэл боловсруулалтыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын бодлогын судалгааны сектор хийж гүйцэтгэсэн. Судалгааны мэдээллийг программд оруулж үр дүнг боловсруулах, анализ хийхэд IBM SPSS-25 программыг ашигласан.



ХОЁРДУГААР БҮЛЭГ.

МАЛЧИД, МАЛЧИН ӨРХИЙН ӨНӨӨГИЙН
БАЙДАЛ






МАЛЧИД, МАЛЧИН ӨРХИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Үндэсний статистикийн хорооны 2022 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малчид 305.1 мянга болж өмнөх оноос 0.4 мянга буюу 0.1 хувиар буурсан байна. Харин 2018 оноос 16.4 мянга буюу 5.7 хувиар өссөн байна. Хөдөлмөрийн насны хүн амын 14.1 хувийг, ажиллагчдын 25.8 хувийг малчид эзэлж байна.

Малчин өрхийн тоо 2022 онд 190.8 мянга болж өмнөх оноос 2.2 мянга буюу 1.2 хувиар нэмэгдсэн байна.


Зураг 4. Малчид, малчин өрхийн тоо, мянган хүн, 2015-2022 он



Малчдыг хүйсээр авч үзвэл 181.8 мянга (59.6 хувь) нь эрэгтэй, 123.3 мянга (40.4 хувь) нь эмэгтэйчүүд байна. Өөрөөр хэлбэл 5 малчин тутмын гурав нь эрэгтэйчүүд байна.

Малчдыг насны бүлгээр авч үзвэл 6.3 хувь нь 15-24 насныхан, 20.6 хувь нь 25-34 насныхан, 28.4 хувь нь 35-44 насныхан, 25.4 хувь нь 45-54 насныхан, 19.3 хувь нь 55, түүнээс дээш насныхан байна. 15-34 насны залуу малчдын хувьд дийлэнх нь эрэгтэйчүүд байна.

Зураг 5. Малчдын тоо, хүйс, насны бүлгээр, мянган хүн, 2022 он





Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn



Малчдыг бүсээр авч үзвэл 25.2 хувь нь Баруун бүс, 41.3 хувь нь Хангайн бүс, 19.8 хувь нь Төвийн бүс, 12.2 хувь нь Зүүн бүс, 1.5 хувь нь Улаанбаатар хотын харьяалалтай байна. Хамгийн их малчидтай аймгийг авч үзвэл Хөвсгөл (10.9 хувь), Өвөрхангай (9.1 хувь), Архангай (8.8 хувь) аймгууд байна.

Зураг 6. Малчдын тоо, аймгаар, мянган хүн, 2022 он



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn

Нийт малтай өрхийн 55 хувь нь 200 хүртэл малтай байна.

Зураг 7. Малтай өрхийн тоо, мянган хүнээр, малын тооны бүлгээр, 2022 он




Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn



2022 оны жилийн эцсийн байдлаар малчдын 37.9 мянга (12.4 хувь)⁵ нь сайн дураар даатгалд хамрагдсан байна. Сайн дураар даатгалд хамрагдсан малчдын тоо өмнөх оноос 11.8 мянга буюу 3.9 пунктээр буурсан байна.


Сайн дураар даатгалд хамрагдсан малчдыг хүйсээр авч үзвэл 18.4 мянга (48.5 хувь) нь эрэгтэй, 19.6 мянга (51.5 хувь) нь эмэгтэйчүүд байна.

Зураг 8. Нийгмийн даатгалд сайн дураар хамрагдсан малчдын тоо, хүйсээр, мянган хүн, 2022 он



Сайн дураар даатгалд хамрагдсан малчдыг насны бүлгээр авч үзвэл 2.2 хувь нь 15-24 насныхан, 12.1 хувь нь 25-34 насныхан, 37.2 хувь нь 35-44 насныхан, 45.1 хувь нь 45-54 насныхан, 3.4 хувь нь 55, түүнээс дээш насныхан байна. Сайн дураар даатгалд хамрагдсан 10 малчин тутмын дөрөв нь 45-54 насныхан байна.

Зураг 9. Нийгмийн даатгалд сайн дураар хамрагдсан малчдын тоо, хүйс, насны бүлэг, хувиар, 2022 он



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn

⁵НДЕГ-ын мэдээ



Малчдын насны бүлэгт харьцуулж үзвэл 15-24 насны малчдын 4.3 хувь нь, 25-29 насны малчдын 6.1 хувь нь, 30-34 насны малчдын 8.3 хувь нь, 35-39 насны малчдын 13.0 хувь нь, 40-44 насны малчдын 19.2 хувь нь, 45-49 насны малчдын 24.8 хувь нь, 50-54 насны малчдын 18.6 хувь нь, 55, түүнээс дээш насны малчдын 5.6 хувь нь сайн дураар даатгалд хамрагдсан байна.

Хүснэгт 1. Нийгмийн даатгалд сайн дураар хамрагдсан малчдын тоо, тухайн насны малчдад эзлэх хувь, хүйсээр, 2022 он

	Сайн дураар даатгалд хамрагдсан малчид			Тухайн насны малчдад эзлэх хувь		
	Нийт	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт	Эмэгтэй	Эрэгтэй
Нийт	37 956	19 555	18 401	12.4%	15.9%	10.1%
15-24	838	312	526	4.3%	6.2%	3.7%
25-29	1 721	871	850	6.1%	8.9%	4.6%
30-34	2 858	1 660	1 198	8.3%	12.4%	5.7%
35-39	5 307	3 256	2 051	13.0%	19.3%	8.6%
40-44	8 808	5 278	3 530	19.2%	26.8%	13.5%
45-49	10 765	6 389	4 376	24.8%	33.6%	17.9%
50-54	6 374	1 642	4 732	18.6%	11.7%	23.5%
55-59	1 190	147	1 043	5.0%	1.5%	7.3%
60-64	94	-	94	0.6%	-	1.0%
65+	1	-	1	-	-	-



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Сайн дураар нийгмийн даатгалд хамрагдсан малчдыг бүсээр авч үзвэл 22.2 хувь нь Баруун бүс, 40.5 хувь нь Хангайн бүс, 23.6 хувь нь Төвийн бүс, 13.0 хувь нь Зүүн бүс, 0.7 хувь нь Улаанбаатар хотоос хамрагдсан байна.

Баруун бүсийн малчдын 11.0 хувь нь, Хангайн бүсийн малчдын 12.2 хувь нь, Төвийн бүсийн малчдын 14.8 хувь нь, Зүүн бүсийн малчдын 13.3 хувь нь, Улаанбаатар хотын малчдын 6.1 хувь нь сайн дураар нийгмийн даатгалд хамрагдсан байна. Дундговь, Дорнод аймгийн малчдын 15.8-19.4 хувь нь сайн дурын даатгалд хамрагдсан байна. Харин Баян-Өлгий аймгийн малчдын 3.8 хувь нь сайн дурын даатгалд хамрагдсан бөгөөд хамрагдалт хамгийн бага байна.



Зураг 10. Нийгмийн даатгалд сайн дураар хамрагдсан малчдын тоо, нийт малчдад эзлэх хувь, аймгаар, мянган хүн, 2022 он




Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn

2022 оны жилийн эцсийн байдлаар малчдын 66.5 мянга (21.8 хувь) нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан малчдын тоо өмнөх оноос 2.7 мянга буюу 3.9 пунктээр буурсан байна.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан малчдыг хүйсээр авч үзвэл 33.9 мянга (51.1 хувь) нь эрэгтэй, 32.5 мянга (48.9 хувь) нь эмэгтэйчүүд байна.

Зураг 11. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан малчдын тоо, хүйсээр, мянган хүн, 2022 он



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn



Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан малчдыг насны бүлгээр авч үзвэл 9.0 хувь нь 15-24 насныхан, 8.0 хувь нь 25-29 насныхан, 10.5 хувь нь 30-34 насныхан, 14.6 хувь нь 35-39 насныхан, 19.6 хувь нь 40-44 насныхан, 21.6 хувь нь 45-49 насныхан, 12.6 хувь нь 50-54 насныхан, 4.1 хувь нь 55, түүнээс дээш насныхан байна. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан малчдыг насны бүлгийн хувьд жигд тархалттай байна.

Малчдын насны бүлэгт харьцуулж үзвэл 15-24 насны малчдын 31.1 хувь нь, 25-29 насны малчдын 18.7 хувь нь, 30-34 насны малчдын 20.2 хувь нь, 35-39 насны малчдын 23.9 хувь нь, 40-44 насны малчдын 28.4 хувь нь, 45-49 насны малчдын 33.0 хувь нь, 50-54 насны малчдын 24.5 хувь нь, 55, түүнээс дээш насны малчдын 12.3 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна.

Хүснэгт 2. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан малчдын тоо, тухайн насны малчдад эзлэх хувь, хүйсээр, 2022 он


	Сайн дураар даатгалд хамрагдсан малчид			Тухайн насны малчдад эзлэх хувь		
	Нийт	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт	Эмэгтэй	Эрэгтэй
Нийт	66 502	32 514	33 988	21.8%	26.4%	18.7%
15-24	6 015	2 611	3 404	31.1%	52.0%	23.8%
25-29	5 302	2 614	2 688	18.7%	26.7%	14.5%
30-34	6 971	3 777	3 194	20.2%	28.1%	15.2%
35-39	9 704	5 255	4 449	23.9%	31.2%	18.7%
40-44	13 030	7 078	5 952	28.4%	35.9%	22.8%
45-49	14 360	8 031	6 329	33.0%	42.3%	25.9%
50-54	8 365	2 778	5 587	24.5%	19.8%	27.8%
55-59	2 384	363	2 021	10.0%	3.8%	14.2%
60-64	354	2	352	2.2%	0.0%	3.8%
65+	17		17	0.1%	0.0%	0.2%

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Баруун бүсийн малчдын 19.5 хувь нь, Хангайн бүсийн малчдын 20.8 хувь нь, Төвийн бүсийн малчдын 25.5 хувь нь, Зүүн бүсийн малчдын 23.7 хувь нь, Улаанбаатар хотын малчдын 23.4 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна.



Зураг 12. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан малчдын тоо, нийт малчдад эзлэх хувь, аймгаар, мянган хүн, 2022 он



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn



ГУРАВДУГААР БҮЛЭГ.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН





Хүн ам зүйн шинж байдал

Судалгаанд нийт 880 малчин өрхийг хамруулж, судалгааны үр дүнг боловсруулахдаа өрхийн мэдээллийг ашиглалаа. Өрхийн гол асуудлыг шийдэхэд голлох үүрэг гүйцэтгэдэг, өрхийн тэргүүн асуудлыг бүрэн хариуцдаг, ихэнх тохиолдолд өрхийн санхүүгийн асуудлыг шийдвэрлэдэг мөн өрхийн гишүүдийн талаар сайн мэддэг иргэдээс судалгааг авсан.


Судалгаанд ярилцлага өгсөн нийт хүний 62.2 хувь нь өрхийн тэргүүн, 34.5 хувь эхнэр/нөхөр, үлдсэн 3.3 хувь нь өрхийн бусад гишүүд байв. Ярилцлага өгөгчийн 61.0 хувь эрэгтэй, 39.0 хувь нь эмэгтэй байсан бөгөөд оролцогчдын дундаж нас 40-49 нас, хамгийн бага нь 18 настай байсан бол хамгийн өндөр 90 настай оролцогчид байлаа. Өрхийн тэргүүлэгчийг боловсролын төвшнөөр нь авч үзвэл дийлэнх нь бүрэн дунд ба түүнээс бага боловсролтой байна.

Зураг 13. Судалгаанд хамрагдсан малчид, өрхийн хамаарлаар



Хүйсийн хувьд судалгаанд хамрагдсан малчдын дунд эрэгтэйчүүд давамгайлж байна. 25-29 насны малчдын 67.6 хувь нь эрэгтэйчүүд, 32.4 хувь нь эмэгтэй байна. Залуучуудын дундах хүйсийн харьцаа зөрүүтэй байгаа нь малчдын дундах гэрлэлт буурах, оройтох, гэр бүл төлөвлөлт орхигдож байгаа нь сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байгааг анхаарах шаардлагатай юм.

Зураг 14. Судалгаанд хамрагдсан малчид, насны бүлэг, хүйсээр





Судалгаанд хамрагдсан малчдын 53.2 хувь нь бүрэн дунд боловсролтой, 18.9 хувь нь бага, 13.9 хувь нь суурь боловсролтой байна. Судалгаанд хамрагдсан 2 малчин тутмын нэг нь бүрэн дунд боловсролтой байна.

Зураг 15. Судалгаанд хамрагдсан малчид, боловсролын түвшнээр




Судалгаанд хамрагдсан малчдаас гэр бүлийн байдлын талаар тодруулахад 81.7 хувь нь гэрлэлтээ батлуулсан байна. Харин 5.5 хувь огт гэрлээгүй байна.

Зураг 16. Судалгаанд хамрагдсан малчид, гэрлэлтийн байдлаар



Судалгаанд оролцсон 880 өрх нийтдээ 3726 гишүүнтэй бөгөөд өрхийн ам бүлийн тоо дунджаар 4.2 байна. Нийт өрхийн 23.4 хувь нь 5 ам бүл, 19.1 хувь нь 4 ам бүл, 18.3 хувь нь 6 ам бүл, 15.5 хувь нь 3 ам бүл, 13.3 хувь нь 2 ам бүлтэй үлдсэн 5.9 хувь нь 7-8 ам бүлтэй, 4.5 хувь нь ганцаараа амьдарч байна.


Зураг 17. Судалгаанд хамрагдсан малчид, ам бүлийн тоогоор






Судалгааг 15 ба түүнээс дээш насны иргэнээс ярилцлага авсан. Судалгаанд хамрагдсан малчин өрхүүдэд МАА-аас өөр төрлийн хөдөлмөр эрхэлдэг өрхийн гишүүд байсан. Тухайлбал нийт судалгаанд хамрагдсан өрхүүдийн 12 хувийн нэг гишүүн нь МАА-аас өөр хөдөлмөр эрхэлж байсан.

Зураг 18. Мал аж ахуйгаас бусад хөдөлмөр эрхлэгч зөвхөн мал аж ахуйгаас бусад хөдөлмөр эрхлэгчдээс дүнд эзлэх хувиар.



Малчдыг мал малласан жилээр нь харвал мал аж ахуй эрхэлж буй малчдын 4.3 хувь нь 1-5 жил, 5.8 хувь нь 6-9 жил, 25.3 хувь нь 10-19 жил, 20.1 хувь нь 20-29 жил, 16.4 хувь нь 30-39 жил, 28.1 хувь нь 40-өөс дээш жил мал малласан байна.

Зураг 19. Мал малласан жил, хүйсээр, насны бүлгээр



Насны бүлгээр нь харьцуулж харвал 45-49 настай малчдын хувьд хамгийн өндөр буюу 28.1 хувь нь 40-өөс дээш жил мал аж ахуй эрхэлсэн байгаа бол хамгийн бага буюу 15-29 настай залуу малчдын 5.5 хувь нь 1-9 жил мал малласан байна.

Малчдын дийлэнх нь мал хариулах, услах, ноос, ноолуур самнах, хяргах, хашаа хороо барих, нутаг сэлгэж нүүх, оторлох, мал зарж борлуулах, өвлийн бэлтгэл хангах зэрэг ажлыг хийдэг.


Малчдын ахуйн хүрээн дэх хөдөлмөр эрхлэлтээр нь харвал малчдын 96.4 хувь мал хариулах ажлыг, 94.8 хувь мал услах ажлыг хийдэг гэж хариулсан бол хамгийн бага хувьтай буюу 41.7 хувь арьс ширэн эдлэлээ борлуулах, 37.4 хувь нь



арьс шир түүхий эд боловсруулах ажлыг хийдэг гэсэн байна. Энэ нь арьс шир боловсруулж бүтээгдэхүүн хийх ажил багасаж дийлэнх малчид зарж борлуулдаг болжээ.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг хүйсээр харвал мал хариулах, мал услах, нүүдэл суудал хийх, мал зарж борлуулах, хашаа хороо барих, хадлан тариа, нэмэлт тэжээл эрдэс бордоо бэлтгэх, арьс шир түүхий эд боловсруулах, борлуулах ажилд эрэгтэйчүүдийн оролцоо эмэгтэйчүүдээс өндөр байгаа бол бусад ажилд эмэгтэйчүүд оролцоо өндөр байна. Судалгаанд хамрагдсан малчдын тухайд байгалийн цаг уурын эрсдэлд нөхцөл байгаа учраас гаднаас хадлан тэжээл худалдаж авдаг. Ногоо бага ургаж байгаа учир бага төлтэй малыг сүүг сааж, цагаан идээ боловсруулах, зарах нь багассан байна.

Зураг 20. Малчдын ахуйн хүрээн дэх хөдөлмөр эрхлэлт





Өрхийн амьжиргаа, хэрэглээ

Малчин өрхийн сарын дундаж орлого

Малчин өрхийн жилийн дундаж орлогыг сард шилжүүлж, зардлыг мөн адил зарчмаар тооцож гаргасан.


Малчдын орлогын эх үүсвэрийг асуухдаа цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, мал аж ахуйн орлого, ХАА-н бусад үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, бусад орлогын эх үүсвэрээр тодотгон асуусан. Судалгаанд хамрагдсан нийт малчдын 13.1 хувь нь цалин хөлсний, 86.5 хувь нь тэтгэвэр, тэтгэмжийн, 98.2 хувь нь ХАА-н үйлдвэрлэлийн, 16.8 хувь нь ХАА-н бус үйлдвэрлэл үйлчилгээний, 6.6 хувь нь хадгаламжийн, 2.7 хувь нь бусад төрлийн орлогын эх үүсвэртэй байна.

Зураг 21. Малчин өрхийн сарын дундаж орлого, эх үүсвэр, хувиар



Судалгаанд хамрагдсан малчин өрхийн сарын дундаж орлого 1512.1 мянган төгрөг байна. Сарын дундаж орлогыг эх үүсвэрийн төрлөөр авч үзвэл, цалин хөлсний орлого дунджаар 953.4 мянган төгрөг, тэтгэвэр тэтгэмжийн орлого дунджаар 375.4 мянган төгрөг, ХАА-н үйлдвэрлэлийн орлого дунджаар 949.6 мянган төгрөг, ХАА-н бус үйлдвэрлэл үйлчилгээний орлого дунджаар 713.7 мянган төгрөг байна.

Зураг 22. Малчин өрхийн сарын дундаж орлого, эх үүсвэр, мянган төгрөг





Малчин өрхийн сарын дундаж орлогыг бүтцээр авч үзвэл 61.7 хувь нь ХАА-н үйлдвэрлэлийн, 21.5 хувь нь тэтгэвэр, тэтгэмжийн, 8.3 хувь нь цалин хөлсний, 7.9 хувь нь ХАА-н бус үйлдвэрлэл үйлчилгээний, 0.6 бусад орлогын эх үүсвэрээс бүрдэж байна.

Зураг 23. Малчин өрхийн сарын дундаж орлого, бүтцээр, хувиар



Малчин өрхийн сарын дундаж орлогын бүтцийг малын тооны бүлгээр авч үзэхэд малын тоо ихсэх тусам орлогод эзлэх цалин хөлс болон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ багасаж байна. Харин малын тоо ихсэх тутам ХАА-н үйлдвэрлэлийн орлого болон ХАА-н бус үйлдвэрлэл үйлчилгээний орлогын эзлэх хувь нэмэгдэж байна.

Хүснэгт 3. Малчин өрхийн сарын дундаж орлого, хонин толгойд шилжүүлсэн малын тооны бүлэг, бүтэц, хувиар

	200, хүртэлх	201-500	501-1000	1001-1500	1501-2000	2001, түүнээс дээш
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%
Цалин хөлс	14.8%	11.1%	9.0%	7.2%	7.3%	0.8%
Тэтгэвэр, тэтгэмж	41.9%	30.3%	23.7%	16.1%	12.8%	6.4%
ХАА-н үйлдвэрлэлийн орлого	38.6%	52.6%	60.4%	69.7%	74.0%	70.4%
ХАА-н бус үйлдвэрлэл үйлчилгээний орлого	4.5%	5.7%	5.9%	6.9%	5.5%	21.5%
Хадгаламжийн хүү	0.2%	0.1%	0.2%	0.1%	0.2%	0.8%
Бусад орлого	0.0%	0.2%	0.8%	0.0%	0.2%	0.1%


Малчин өрхийн сарын дундаж орлогыг хот, хөдөөгөөр авч үзэхэд хот, суурин газраас хамрагдсан малчдын орлого дунджаар 1755.3 мянган төгрөг, хөдөө, орон нутгаас хамрагдсан малчдын орлого дунджаар 1493.9 мянган төгрөг байна. Хот, хөдөөгөөс хамрагдсан малчдын орлогын зөрүү дунджаар 261.4 мянган төгрөг байна.

Хот суурин газарт ойролцоо амьдарч байгаа малчдын өрхийн гишүүдийн хувьд хөдөлмөр эрхлэх нь хөдөө орон нутгийн малчдаас хамаагүй их боломжтой




байдаг. Үүнээс шалтгаалж хот, суурийн газраас хамрагдсан малчдын цалин хөлсний дундаж орлого хөдөө, орон нутгийн малчдаас 54.8 хувиар их байна.

Зураг 24. Малчин өрхийн сарын дундаж орлого, хот, хөдөөгөөр, мянган төгрөг



Малчин өрхийн сарын дундаж орлогыг хонин толгойд шилжүүлсэн малын тоогоор авч үзвэл 1001-1500 малтай малчдын орлого дунджаас 26.4 хувиар, 1501-2000 малтай малчдын орлого дунджаас 58.7 хувиар, 2001, түүнээс дээш малтай малчдын орлого дунджаас 2.5 дахин их байна. Харин 200 хүртэлх малтай малчдын орлого дунджаас 43.8 хувиар, 201-500 малтай малчдын орлого дунджаас 24.9 хувиар, 501-1000 малтай малчдын орлого дунджаас 10.1 хувиар бага байна.

Зураг 25. Малчин өрхийн сарын дундаж орлого, хонин толгойд шилжүүлсэн малын тооны бүлгээр, мянган төгрөг



Судалгаанд хамрагдсан малчид ХАА-н үйлдвэрлэлийн орлогоор сард дунджаар 949.6 мянган төгрөг олж байгаа бол 2001, түүнээс дээш малтай малчдын орлого дунджаас 2.8 дахин их байна. Мөн 2001, түүнээс дээш малтай малчдын ХАА-н бус үйлдвэрлэл үйлчилгээний орлого нь дунджаас 2.7 дахин их байна.



Хүснэгт 4. Малчин өрхийн сарын дундаж орлого, хонин толгойд шилжүүлсэн малын тооны бүлэг, орлогын эх үүсвэрээр, мянган төгрөг

	Нийт	200, хүртэлх	201- 500	501- 1000	1001- 1500	1501- 2000	2001, түүнээс дээш
Дундаж	1512.1	850.1	1135.9	1359.0	1910.9	2399.6	3757.9
Цалин хөлс	953.5	798.9	858.2	971.2	1204.5	1224.6	733.3
Тэтгэвэр, тэтгэмж	375.4	433.5	401.4	358.0	341.0	357.7	331.2
ХАА-н үйлдвэрлэлийн орлого	949.6	345.8	608.2	832.0	1332.0	1776.5	2705.6
ХАА-н бус үйлдвэрлэл үйлчилгээний орлого	713.7	241.7	480.6	479.5	766.9	925.9	1960.5
Хадгаламжийн хүү	57.3	31.2	32.4	53.9	50.6	35.1	111.8
Бусад орлого	183.1	9.3	123.0	389.7	33.3	57.2	125.0

Малчин өрхийн сарын дундаж зарлага

Малчин өрхийн зарлагын бүтцийг асуухдаа хүнсний бүтээгдэхүүн, малын тэжээл, эм тарилга, шатахуун, сургалтын төлбөр, хувцас, гэр ахуйн бараа, туслах малчны цалин, хөлс, зээлийн төлбөр, түлш (түлээ нүүрс), харилцаа холбоо, боловсролын зардал, эрүүл мэндийн үйлчилгээ болон бусад зардал зэргээр задлан асуусан. Зардал бүтцээр асуух явцад 2023 оны хавар хатуу (зуд ихтэй, цас их орсон) орсон тул малын тэжээл, эм тарилгад өмнөх жилүүдийнхээс хоёроос гурав дахин их зардал гаргасан гэж дурдаж байсан.

Судалгаанд хамрагдсан малчин өрхийн ихэнх нь хүнсний бүтээгдэхүүн, малын тэжээл, эм тарилга, шатахуун, хувцас, гэр ахуйн бараа, харилцаа холбоонд зардал гаргасан байна. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 80.0 хувь нь эрүүл мэндийн үйлчилгээнд, 64.0 хувь нь боловсролд, 63.9 хувь нь зээлийн төлбөрт, 42.3 хувь нь түлээ, нүүрсэнд, 16.4 хувь нь сургалтын төлбөрт, 5.0 хувь нь туслах малчны цалин хөлсөнд өнгөрсөн жил давхардсан тоогоор зарцуулсан байна.




Зураг 26. Малчин өрхийн сарын дундаж зардал, төрөл, хувиар



Судалгаанд хамрагдсан малчин өрхийн сарын дундаж зарлага 2086.8 мянган төгрөг байна. Сарын дундаж зардал төрлөөр авч үзвэл, хүнсэнд дунджаар 375.2 мянган төгрөг, малын тэжээл, эм тарилгад дунджаар 367.4 мянган төгрөг, шатахуунд дунджаар 323.8 мянган төгрөг, хувцас, гэр ахуйн бараанд дунджаар 713.7 мянган төгрөг, харилцаа холбоонд дунджаар 65.6 мянган төгрөг зарцуулж байна.

Зураг 27. Малчин өрхийн сарын дундаж зардал, төрөл, мянган төгрөг



Малчин өрхийн сарын дундаж зардлыг бүтцээр авч үзвэл 18.9 хувь нь зээлийн төлбөр, 18.0 хувь нь хүнсний бүтээгдэхүүн, 17.6 хувь нь малын тэжээл, эм тарилга, 15.0 хувь нь шатахуун, 9.9 хувцас, гэр ахуйн бараа, 6.3 боловсролын зардал, үлдсэн 14.3 хувь нь бусад зардлаас бүрдэж байна.



Зураг 28. Малчдын сарын дундаж зардал, бүтэц, хувиар



Малын тоо ихсэх тусам зардалд эзлэх шатахууны зардлын хэмжээ, туслах малчны цалин хөлсний хэмжээ ихсэж байна. Харин малын тоо багасах тусам зардалд эзлэх хүнсний бүтээгдэхүүний зардлын хэмжээ ихсэж байна. Бусад зардлын хувьд малын тооноос үл хамааран эзлэх хувь ойролцоо байна.


Хүснэгт 5. Малчин өрхийн сарын дундаж зардал, хонин толгойд шилжүүлсэн малын тооны бүлэг, бүтцээр, хувиар

	200, хүртэлх	201-500	501-1000	1001-1500	1501-2000	2001, түүнээс дээш
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%
Хүнсний бүтээгдэхүүн	22.1%	20.1%	18.1%	16.7%	16.0%	13.9%
Малын тэжээл, эм тарилга	14.5%	18.3%	16.7%	19.8%	16.4%	17.6%
Шатахуун	14.7%	13.8%	15.2%	15.1%	15.3%	17.6%
Сургалтын төлбөр	1.7%	3.8%	4.4%	4.3%	7.6%	3.8%
Хувцас, гэр ахуйн бараа	11.0%	10.3%	9.8%	9.5%	10.4%	9.2%
Туслах малчны цалин, хөлс	0.4%	0.4%	0.4%	0.6%	4.2%	8.4%
Зээлийн төлбөр	16.8%	19.3%	20.5%	19.4%	16.4%	15.8%
Түлш (Түлээ нүүрс)	3.8%	2.1%	1.3%	1.7%	0.7%	1.0%
Харилцаа холбоо	3.8%	3.2%	3.1%	2.9%	3.2%	2.8%
Боловсролын зардал	5.3%	5.2%	6.7%	6.9%	6.6%	7.4%
Эрүүл мэндийн үйлчилгээ	5.6%	3.1%	3.5%	2.8%	3.0%	2.3%
Бусад	0.3%	0.4%	0.3%	0.3%	0.2%	0.2%



Малчин өрхийн сарын дундаж зардлыг хот, хөдөөгөөр авч үзэхэд хот, суурин газраас хамрагдсан малчин өрхийн зардал дунджаар 2113.6 мянган төгрөг, хөдөө, орон нутгаас хамрагдсан малчин өрхийн зардал дунджаар 2084.8 мянган төгрөг байна. Хот, хөдөөгөөс хамрагдсан малчдын зардал бараг зөрүүгүй байна.


Зураг 29. Малчин өрхийн сарын дундаж зардал, хот, хөдөөгөөр, мянган төгрөг



Малчин өрхийн сарын дундаж зарлагыг хонин толгойд шилжүүлсэн малын тоогоор авч үзвэл 1001-1500 малтай малчдын зарлага дунджаас 23.3 хувиар, 1501-2000 малтай малчдын зарлага дунджаас 43.8 хувиар, 2001, түүнээс дээш малтай малчдын зарлага дунджаас 88.8 хувиар их байгаа бол 200 хүртэлх малтай малчдын зарлага дунджаас 42.5 хувиар, 201-500 малтай малчдын зарлага дунджаас 18.7 хувиар, 501-1000 малтай малчдын зарлага дунджаас 1.9 хувиар бага байна.



Зураг 30. Малчин өрхийн сарын дундаж орлого, хонин толгойд шилжүүлсэн малын тооны бүлгээр, мянган төгрөг



Тоон мэдээллээс харахад малын тоо нэмэгдэхэд малчин өрхийн зардал ихээр нэмэгдэж байна. Малын тоо нэмэгдэхэд хүнсний бүтээгдэхүүн, малын тэжээл, эм тарилга, шатахуун, хувцас, гэр ахуйн бараа, туслах малчны цалин, хөлс, зээлийн төлбөр, харилцаа холбоо, боловсролын зардлын хэмжээ дунджаас 1-2 дахин их байна.

Судалгаанд хамрагдсан малчин өрх сард шатахуунд дунджаар 323.8 мянган төгрөг зарцуулж байгаа бол 2001, түүнээс дээш малтай малчид дунджаас 2.1 дахин их хэмжээний мөнгийг шатахуунд зарцуулж байна.

Зээлтэй малчин өрхийн хувьд зээлийн төлбөрт сард дунджаар 616.6 мянган төгрөг төлж байгаа бол 2001, түүнээс дээш малтай малчид зээлийн төлбөр дунджаас 1.7 дахин их хэмжээний мөнгийг төлж байна.

Хүснэгт 6. Малчин өрхийн сарын дундаж зарлага, хонин толгойд шилжүүлсэн малын тооны бүлэг, орлогын эх үүсвэрээр, мянган төгрөг

	Нийт	200, хүртэлх	201-500	501-1000	1001-1500	1501-2000	2001, түүнээс дээш
Дундаж	2086.8	1200.7	1696.0	2047.9	2572.4	3001.2	3939.5
Хүнсний бүтээгдэхүүн	375.2	265.4	340.4	371.4	429.0	480.3	545.7
Малын тэжээл, эм тарилга	367.2	176.1	311.6	342.6	509.3	490.9	691.5
Шатахуун	323.8	209.1	243.8	312.4	388.1	459.3	694.6
Сургалтын төлбөр	554.4	275.0	537.2	539.9	681.9	596.5	527.4
Хувцас, гэр ахуйн бараа	219.8	146.1	187.6	209.5	257.2	311.8	381.0
Туслах малчны цалин, хөлс	675.7	500.0	467.5	441.6	666.7	722.7	760.1
Зээлийн төлбөр	616.6	422.2	496.2	611.8	785.9	796.2	1021.0
Түлш (Түлээ нүүрс)	81.3	110.3	81.9	69.6	84.5	55.6	109.9
Харилцаа холбоо	65.6	46.1	55.0	64.1	75.9	94.5	111.2
Боловсролын зардал	206.2	161.8	158.3	203.6	229.1	241.8	345.7
Эрүүл мэндийн үйлчилгээ	84.7	81.0	65.2	93.6	89.3	101.1	123.4
Бусад	93.2	44.5	98.2	87.7	114.1	68.2	200.0




Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 63.4 хувь нь зээлтэй байна. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан 10 малчин өрх тутмын зургаа нь зээлтэй байна. Зээлийн зориулалтаар авч үзэхэд давхардсан тоогоор 88.2 хувь нь малчны зээл, 9.7 хувь нь тэтгэврийн зээл, 5.6 хувь нь өрхийн хэрэглээний зээл, 4.7 хувь нь цалингийн зээл, үлдсэн 3.8 хувь нь бусад төрлийн зээл байна.

Зураг 31. Малчин өрхийн зээл, зээлийн зориулалт, хувиар



Зураг 32. Зээлтэй малчдын эзлэх хувь, хонин толгойд шилжүүлсэн малын тоогоор




Малчин өрхийн орлого, зарлагын зөрүү

Судалгаанд хамрагдсан малчин өрхийн сарын дундаж орлого, зарлагын зөрүү 547.7 мянган төгрөг байгаа бөгөөд зарлагад эзлэх орлогын хувь 72.5 байна. Орлого, зарлагын зөрүүг зээлийн төлбөртэй харьцуулж үзэхэд ойролцоо байгаа бөгөөд өнгөрсөн жилд зээл авч өрхийн зарлагаа нөхсөн байх магадлалтай харагдаж байна.




Зураг 33. Малчин өрхийн сарын дундаж орлого, зарлагын зөрүү, мянган төгрөг



Хот, суурин газраас хамрагдсан малчин өрхийн орлого, зарлагын зөрүү 358.3 мянган төгрөг, хөдөө, орон нутгаас хамрагдсан малчдын орлого зарлагын зөрүү 590.8 мянган төгрөг байна. Хот, суурин газраас хамрагдсан малчид зарлагынхаа 83.0 хувийг, хөдөө, орон нутгаас хамрагдсан малчид зарлагынхаа 71.7 хувийг орлогоороо нөхөж байна. Хот, хөдөөгөөс хамрагдсан малчдын сарын дундаж зарлагын хувьд зөрүү бага байгаа хэдий ч орлогын хувьд зөрүүтэй байна.

Зураг 34. Малчин өрхийн сарын дундаж орлого, зарлагын зөрүү, хот, хөдөөгөөр, мянган төгрөг



Судалгаанд хамрагдсан малчин өрхийн сарын дундаж орлого, зарлагын зөрүү хонин толгойд шилжүүлсэн малын тооны бүлгээр авч үзвэл, 2001, түүнээс дээш малтай малчдын орлого зарлагын зөрүү хамгийн бага буюу 181.7 мянган төгрөг, 501-1000 малтай малчдын орлого зарлагын зөрүү хамгийн их буюу 688.9 мянган төгрөг байна. 2001, түүнээс дээш малтай малчид зарлагынхаа 66.4 хувийг, 501-1000 малтай малчид зарлагынхаа 95.4 хувийг орлогоороо нөхөж байна. Малын тоо ихсэх тусам орлогоороо зарлагаа нөхсөн байдал нь ихсэж байна.

Зураг 35. Малчин өрхийн сарын дундаж орлого, зарлагын зөрүү, хонин толгойд шилжүүлсэн малын тоогоор, мянган төгрөг

Орлого, зарлагын зөрүү



Зарлагад эзлэх орлогын хувь





Урамшуулалд хамрагдсан байдал

Судалгаанд хамрагдсан малчдын 26.9 хувь нь сүүлийн нэг жилд ямар нэгэн урамшуулал авсан байна. Урамшуулал авсан малчдын 86.5 хувь нь ноос, ноолуурын, 23.6 хувь нь арьс, ширний, 8.9 хувь нь сүүний урамшуулал авсан байна. Ноос, ноолуурын урамшуулал авсан малчид дунджаар 317.0 мянган төгрөг, арьс, ширний урамшуулал авсан малчид дунджаар 163.3 мянган төгрөг, сүүний урамшуулал авсан малчид дунджаар 1069.5 мянган төгрөг авсан байна. Сүүний урамшуулал авсан малчдын ихэнх нь хосолсон мал аж ахуй эрхлэгч байсан.

Зураг 36. Мөнгөн урамшуулал авсан малчид, урамшууллын төрөл, хувиар



Урамшуулал авсан малчдын 74.7 хувь нь мөнгөн урамшууллаар НДШ, ЭМД-ыг төлөхийг зөвшөөрсөн бол 15.2 хувь нь зөвшөөрөөгүй, 10.1 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Өөрөөр хэлбэл ямар нэгэн урамшуулал авсан 4 малчид тутмын гурав нь тухайн урамшууллаар НДШ, ЭМД-ыг төлөхийг зөвшөөрчээ. Малчдын хувьд тухай бүр очиж НДШ, ЭМД төлөх боломжгүй байдаг тул мөнгөн урамшууллаар НДШ, ЭМД төлөхийг дэмжиж байсан.

Малын тоог хонин толгойд шилжүүлсэн дүнгээр 200 хүртэлх малтай малчдын 55.6 хувь нь, 201-500 малтай малчдын 74.5 хувь нь, 501-1000 малтай малчдын 71.8 хувь нь, 1001-1500 малтай малчдын 81.6 хувь нь, 1501-2000 малтай малчдын 85.7 хувь нь, 2001, түүнээс дээш малтай малчдын 68.2 хувь нь НДШ, ЭМД-ыг төлөхийг зөвшөөрсөн байна.

Зураг 37. Мөнгөн урамшууллаар НДШ, ЭМД-ыг төлөхийг зөвшөөрсөн малчдын хувь, хонин толгойд шилжүүлсэн малын тооны бүлгээр






Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын хамрагдалт

Малчдад нийгмийн даатгалын талаар анхан шатны ойлголт, байдаггүйгээс шимтгэлээ тогтмол төлөхгүй, дундаас нь орхих, даатгалын тэтгэмжээ авах эрхтэй байсан ч нэхэмжлэхгүй байгааг Малчдын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын талаарх зан үйлийн судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Судалгаанд оролцсон нийт малчин өрхийн 39.2 хувь буюу эрэгтэйчүүдийн 22.0 хувь, эмэгтэйчүүдийн 17.2 хувь нь нийгмийн даатгалын талаар бага ч гэсэн мэддэг бол бусад хувь нь мэддэггүй гэж хариулсан. Эрэгтэйчүүд нийгмийн даатгалын талаар ойлголтгүй байх нь их байна.


Зураг 38. Судалгаанд хамрагдсан малчдын нийгмийн даатгалын талаарх хэр сайн мэдэх вэ?




Малчин өрхөөс “Хөдөлмөрийн насны хэдэн гишүүд НД -д хамрагддаг вэ?” гэсэн асуултад судалгаанд оролцсон малчдын 55.3 хувь нь эрүүл мэндийн даатгал төлдөг бол 44.7 хувь нь төлдөггүй, 59.8 хувь нь сайн дурын нийгмийн даатгалын шимтгэлийг төлдөг бол 40.2 хувь нь төлөөгүй байна. Судалгаанд оролцсон малчдын нийгмийн даатгал төлсөн байдал 60.9 хувь нь эрэгтэй, 39.1 хувь нь эмэгтэй байна.

Зураг 39. Хөдөлмөрийн насны гишүүдийн нийгмийн даатгалын хамрагдалт

Эрүүл мэндийн даатгал



Сайн дурын нийгмийн даатгал





Сайн дураараа нийгмийн даатгалд хамрагдаж чадахгүй байгаа малчин өрхийн шалтгааныг нь тодруулахад 29.3 хувь нь санхүүгийн боломжгүй (эрэгтэйчүүдийн 55.0 хувь, эмэгтэйчүүдийн 45 хувь), 16.3 хувь нь нийгмийн даатгалын ач холбогдлыг мэдэхгүй гэж хариулсан малчдын эрэгтэйчүүдийн 65.0 хувь, эмэгтэйчүүдийн 35.0 хувиас илүү өндөр хувьтай байна. Харин 12.3 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл өндөр, 12.6 хувь нь тэтгэвэрт гарсан бол 5.7 хувь нь шаардлагагүй, 5.6 хувь нь нийгмийн даатгалд яаж хамрагдах аргаа мэдэхгүй байна. Харин 18.2 хувь нь бусад оюутан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна.

Зураг 40. Малчин өрхийн гишүүд сайн дурын даатгалд хамрагдахгүй байгаа шалтгаан




Нийгмийн даатгалд хамрагдаагүй шалтгааныг насны бүлгээр ангилж үзвэл 30-49 насныхан хамгийн өндөр буюу 37.2 хувь нь санхүүгийн боломжгүй, 25-29 настай залуучуудын хувьд яаж хамрагдах аргаа мэдэхгүй байгаа бол 35-39 настай нийгмийн даатгал төлөх боломжтой малчдын 23.8 хувь нийгмийн даатгалын ач холбогдлыг нь мэдэхгүй мөн шаардлагагүй гэж үзжээ.

Хүснэгт 7. Нийгмийн даатгалд хамрагдаагүй шалтгаан насны бүлгээр

	15-24 нас	25-29 нас	30-34 нас	35-39 нас	40-44 нас	45-49 нас	50-54 нас	55-59 нас	60, дээш
Санхүүгийн боломжгүй	15.8%	36.6%	37.3%	39.7%	36.1%	35.5%	31.4%	26.7%	10.6%
Нийгмийн даатгалын ач холбогдлыг нь мэдэхгүй	15.8%	22.5%	33.7%	28.1%	18.8%	16.4%	9.3%	6.7%	1.2%
Нийгмийн даатгалд яаж хамрагдах аргаа мэдэхгүй	5.3%	18.3%	8.4%	5.0%	5.3%	5.3%	4.7%	4.4%	1.2%
Шаардлагагүй	15.8%	5.6%	2.4%	9.9%	7.5%	4.6%	4.7%	8.9%	4.7%
Тэтгэвэрт	5.3%	4.2%	2.4%	1.7%	0.8%	0.0%	17.4%	42.2%	80.0%
Нийгмийн даатгалын шимтгэл өндөр	31.6%	8.5%	15.7%	8.3%	16.5%	19.7%	22.1%	4.4%	0.0%
Бусад /Бичих/	10.5%	4.2%	0.0%	7.4%	15.0%	18.4%	10.5%	6.7%	2.4%



Зураг 41. Малчид нийгмийн даатгал төлснөөр нийгмийн баталгаа хангагдана гэж бодож буй эсэх




Малчдын хувьд нийгмийн даатгал төлөх эсэх нь сайн дурын асуудал боловч энэ нь ирээдүйд гарах эрсдэлийг бууруулах, байнгын орлоготой байх үндэс суурийг бий болгож өгдөг. Судалгаанд хамрагдсан малчдын 49.4 хувь нь нийгмийн баталгаа хангагдана гэсэн ойлголттой байгаа бол 10.2 хувь нь нийгмийн баталгаа хангагдахгүй буюу 36.3 хувь нь мэдэхгүй гэсэн байна.

Судалгааны үр дүнгээс харахад нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа болон шимтгэл төлөөгүй малчдаас зохистой шимтгэлийн хэмжээг хэд болговол малчид илүү их хамрагдах боломжтой талаар тодруулахад хамгийн өндөр хувьтай буюу 34.6 хувь нь 41.0-50.0 төгрөг болговол боломжийн гэсэн бол 7.3 хувь нь 71.0 – 80.0 мянга төгрөг буюу одоогийн төлж буй шимтгэлийн хэмжээг боломжийн гэж үзсэн харин мал ихтэй малчдын 0.8 хувь нь 100.0 мянга төгрөг буюу түүнээс дээш төлөх боломжтой байна.

Сүүлийн жилүүдэд цөлжилт болон их гантай зуны улмаас малын хоол хүнс хомсдож, тарга тэвээрэг суларснаар малчид хахир өвөлд мал сүргээ олноор алдсан ба малын тэжээлдээ өрхийн орлогынхоо дийлэнх хувийг зарцуулдаг байна.

Зураг 42. Нийгмийн даатгалын шимтгэл хэдэн төгрөг байвал даатгуулах боломжтой болох талаар хариулсан байдал.




Малчдын хөдөлмөрийн үнэлэмж, орлого, нийгмийн асуудал нь малынхаа ашиг шимтэй уялддаг. Учир нь малчин өрхийн орлого бол түүхий эд юм. Малчдын хувьд орлого нь улирлын чанартайгаас гадна, газарзүйн байршлаас шалтгаалан



өөр байдаг ба судалгааны үр дүнгээс харахад малчдын 37.4 хувь нь хагас жилд нэг удаа ноолуур гарах үеэр, 26.2 хувь нь жилд нэг удаа мал зарж, борлуулах цагаар төлөх сонирхолтой байгаа бол 23.8 хувь нь сардаа нэг удаа буюу төв суурин газрын малчид байна. Харин хэдэн сард төлөх боломжоор нь харвал 5 юм уу 6 сард төлөх сонирхолтой малчдын 40.2 хувь нь байгаа бол 30.7 хувь 9-11 сард идэшний цагаар гэж хариулсан. Нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээг сард дунджаар 43.73 мянган төгрөг байвал төлөх боломжтой гэж үзсэн.

Зураг 43. Нийгмийн даатгалын шимтгэлийг хэдийд төлөх боломжтой эсэх





ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Малчдын орлого болон зардлын хэмжээ нь суурьшлын ялгаатай байдал, малын тоо хэмжээ, мал маллагааны арга хэлбэрээс хамааран өөрчлөгдөж байна. Гэхдээ малчид хаана амьдарч байгаагаас үл хамааран зардал нь орлогоосоо давсан байна. Энэ нь малчдад чиглэсэн өрхийн орлого зарлагыг хөтлөх, төлөвлөх зэрэг санхүүгийн мэдлэг олгох сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах шаардлагатай байгааг илтгэнэ. Зардлын дийлэнх хэсэг хүнсэнд, зээлийн төлбөрт, мөн малын тэжээл, эм тарилгад зарцуулагдаж байна.

Судалгаанд оролцсон малчдын дийлэнх нь зээлтэй бөгөөд зээлийн хэмжээ нь малын тооноос хамаарч өөр өөр байна. Малчны зээлд түлхүү хамрагдаж байна.

Малчдын нийгмийн даатгалын талаарх анхан шатны ойлголт дутмаг байгаагаас нийгмийн даатгалд хамрагдахгүй, шимтгэлээ тогтмол төлөхгүй, зогсоход хүргэж байна. Нийгмийн даатгалын шимтгэлийг мөнгөн хэлбэрээр төлөх нь нийгмийн даатгалд хамрагдахгүй байх гол шалтгаан болж байна. Мөн малчид одоогийн төлж буй сайн дурын даатгалын шимтгэлийн доод хэмжээг өндөр гэж үзсэн.

Хөдөлмөр эрхлэлтийн хувьд малчдад тогтсон ажлын цаг байхгүй, харин улирлын онцлог, малын тооноос хамааран хөдөлмөрт зарцуулах цаг өөр өөр байдаг байна. Сүүлийн жилүүдэд мал маллахад байгаль цаг уурын өөрчлөлтөөс үүдэлтэй бэрхшээл тохиолдох нь элбэг байна.

Малчдын ахуйн хүрээн дэх хөдөлмөр эрхлэлтийг харвал мал хариулах ажлыг (96.4 хувь), мал услах ажлыг (94.8 хувь) дийлэнх нь хийдэг бол арьс ширэн эдлэлээ борлуулах (41.7 хувь), арьс шир түүхий эд боловсруулах (37.4 хувь) харьцангуй бага хувьтай хийж гүйцэтгэж байна. Мал хариулах, мал услах, нүүдэл суудал хийх, мал зарж борлуулах, хашаа хороо барих, хадлан тариа, нэмэлт тэжээл эрдэс бордоо бэлтгэх, арьс шир түүхий эд боловсруулах, борлуулах ажилд эрэгтэйчүүдийн оролцоо эмэгтэйчүүдээс өндөр байна.

Судалгаанд хамрагдсан малчдын тухайд нийгмийн даатгалд хамрагдах хувь хэмжээ нь хүн ам зүй, боловсролын түвшин орлого зэрэг нийгмийн үзүүлэлтүүдээс хамаарч өөр өөр байна. Дээд боловсролтой, өрхийн орлого хүрэлцээтэй малчид нийгмийн даатгалын талаар тодорхой ойлголттой, мөн хамрагдах хүсэлтэй байна. Тухайлбал сайн дураар нийгмийн даатгалд хамрагдсан малчид хүйсээс үл хамаарч 40-өөс дээш насандаа илүү их хамрагдаж байна. Өөрөөр хэлбэл тэтгэврийн нас дөхөх тусам нийгмийн даатгалд хамрагдах сонирхол өндөр болж байна.



2022 оны жилийн эцсийн байдлаар малчдын 37.9 мянга (12.4 хувь) нь сайн дураар даатгалд хамрагдсан байна. Сайн дураар даатгалд хамрагдсан малчдын тоо өмнөх оноос 11.8 мянга буюу 3.9 пунктээр буурсан байна. Энэ нь дийлэнх малчдын хувьд ирээдүйд гарч болох нийгэм-эдийн засгийн эрсдэлээс сэргийлэх боломж алдагдаж буйг харуулж байна. Судалгааны үр дүнгээс харахад малчдын хүн ам зүйн шинж байдал, хууль эрх зүйн зохицуулалтаас нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ, төлөх нөхцөл, хэлбэрээс хамаардаг байна.

Монгол улсын Их хурал, Засгийн газраас хэрэгжүүлж буй ноос болон арьс ширний урамшуулалд хамрагдсан малчдын урамшуулал авсан (74.7 хувь нь) мөнгөн урамшууллаар НДШ, ЭМД-ыг төлөхийг зөвшөөрсөн.

Малчдын одоогийн төлж буй сайн дурын даатгалын шимтгэлийн доод хэмжээг өндөр гэж үзсэн ба тэд шимтгэлийн хэмжээг 40-50 мянган төгрөг, хагас жилд нэг удаа 5 ба 11 дүгээр сард төлөх сонирхолтой ба гэр бүлийн хамт хамрагдахаар байна.

Мөн малчдын дунд эрэгтэй 40-өөс дээш насны малчид дийлэнх болж байна.

Санал, зөвлөмж

Энэхүү судалгааны ажлын үр дүнд үндэслэн дараах санал зөвлөмжийг бодлого боловсруулагч болон шийдвэр гаргагчдад хүргүүлж байна.

- Малчдын нийгмийн даатгалын үр ашгийг бүх талаар таниулан, сурталчлахад анхаарч ажиллах нь үр дүнтэй.
- Шимтгэлийн төлөлтийн хэлбэрийг шууд бэлэн мөнгө гэж авахаас илүүтэй ноос ноолуур, арьс ширний урамшуулал, мал, малын түүхий эдээр орлуулах хэлбэрээр авч байхыг санал болгож байна.
- Судалгаанд оролцсон малчдын дийлэнх нь зээлтэй бөгөөд зээлийн хэмжээ нь малын тооноос хамаарч өөр өөр байна. Зээлийн зориулалт ихэнхдээ малдаа зарцуулагдаж байна. Малчдын орлого тогтмол бус байгаагаас шалтгаалан төлөвлөгдөөгүй зардал гаргаж байгаа нь өрхийн амьжиргаанд дарамт үүсгэх, жилд цөөн тоотой орж ирж буй орлого нь нэг юм уу хоёр удаа зээл төлөхөд зарцуулагддаг. Иймээс малчдын орлого, түүнээс үүдэн хуримтлалыг бий болгох, зээлийн ачааллыг бууруулах шаардлагатай байна.



- Малын түүхий эдийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх. Дулааны улиралд арьс шир зарж борлуулахад үнэ хүрдэггүй учир хаях нь элбэг байдаг. Иймд малын гаралтай түүхий эдийг ашиглах, үр ашгийг нэмэгдүүлэх гарц боломжийг судлах шаардлагатай байна.
- Цаашид залуу малчин гэр бүлүүдийг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай байна.